



ХУУЛЬ САХИУЛАХ АЖИЛЛАГАА: Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл аймгийн хууль сахиулах байгууллагын зарим үйл ажиллагаанд хийсэн мониторинг

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Нээлттэй Нийгэм Форум нь Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийг байнга дэмжиж ирсэн бөгөөд шинэчлэлийн үйл явцыг мэдээллээр хангах зорилгоор судалгаа, мониторинг хийлгэх, хэлэлцүүлэг өрнүүлэх зэргээр ажилладаг билээ. Энэ хүрээнд хууль сахиулах салбарт мониторинг хийх тэтгэлгийг Төр иргэн түншлэл, Хөвсгөл далай ээж, Эх нутаг, Хийморьтны ухаан, НДЭХ-ний Өмнөговь аймаг дах салбарт олгосон юм. Мониторингд Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл аймгийн хууль сахиулах байгууллагын зарим үйл ажиллагааг хамрууллаа. Мониторингийн дүнгээс харахад хууль сахиулах байгууллага, орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын хооронд хамтын ажиллагаа бий болж, хууль сахиулах байгууллагын алба хаагчдын сэтгэлгээнд өөрчлөлт гарч, иргэдийн дундах “хүчний байгууллага” хэмээх буруу ойлголтыг залруулах эхлэл тавигджээ хэмээн дүгнэж болохоор байна.

Мониторинг тус бүрийн дэлгэрэнгүй тайланг www.forum.mn цахим хуудаснаас үзэх боломжтой.

МОНИТОРИНГИЙН ДҮН

НЭГ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ГАРГАСАН ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ (Орхон аймаг, Төр иргэн түншлэл ТББ)

Зорилго: Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн болон гэмт хэргийн шинжтэй байж болох үйлдэлд иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж буй байдал, иргэдийн сэтгэл ханамжийг судлах

- Орхон аймгийн цагдаагийн газарт 2014 оноос 2016 оны эхний 10 сарын байдлаар алба хаагчийн сахилга, ёс зүйн зөрчилтэй холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлыг авч судлахад нийт гомдлын 9% гэмт хэргийн шинжтэй байсан тул харъяалах байгууллагад шилжүүлжээ. Үлдсэн гомдлын 23%-д албанаас халах, 51%-д цалинг 1-6 сарын хугацаанд 20% бууруулах, 14%-д сануулах, 1%-д цол бууруулах, 11%-д гомдлыг үндэслэлгүй гэж хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Гурван жилийн дүнг үзэхэд энэ чиглэлийн өргөдөл, гомдол буурах хандлагатай байна.
- Хэдийгээр цагдаагийн газарт ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж байгаа ч өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд иргэдийн сэтгэл ханамж дундуур байна. Мониторингийн явцад



МОНИТОРИНГИЙН ОЛОЛТ, АМЖИЛТ

Орхон аймаг

- Цагдаагийн газар, ТББ-ын хамтын ажиллагаа бий болсон нь нийгмийн сэтгэл зүйд эерэгээр нөлөөлж, эргэх холбоо сайжирлаа.
- Мониторингийн явцад алба хаагчдын үүрэг хариуцлага дээшилж, үйл ажиллагаанд оролцох хүсэлтийг уриалгахнаар хүлээн авч дэмжлэг туслалцаа үзүүлж ажилласан.
- Цагдаагийн газар нь алба хаагчийн сахилга, ёс зүйн болон гэмт хэргийн шинжтэй байж болох үйлдэлд иргэд, ААН-ээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хийсэн мониторингийн үр дүнг хүлээн зөвшөөрч, хамтран ажиллахаар боллоо.

Өмнөговь аймаг

- Зөвлөмжийн дагуу олон нийтийн цагдаагийн ажилтнуудыг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад хэрхэн ажиллах талаар дадлагажууллаа.
- Олон нийтийн цагдаагийн цугларалт сургалтыг хийхээр төлөвлөсөн тухайгаа аймгийн Цагдаагийн газраас мониторингийн багийнханд танилцуулсан.

судалгаанд хамрагдсан 200 иргэний 9% өргөдөл гомдол гаргаж байсан гэж хариулснаас 67% нь өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд сэтгэл ханамжгүй гэж хариулжээ.

- Сахилга, ёс зүйн зөрчил гаргасан нь нотлогдоогүй, үндэслэлгүй гэж үзсэн бүх гомдол 2016 онд харъяалагдаж байгаа бөгөөд энэ нь 2016 оны эхний 10 сарын байдлаар ирсэн нийт гомдлын 57%-ийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Нөгөө талаас иргэдийн гомдол шийдвэрлэлтэд сэтгэл ханамжгүй байгаа нь үүнтэй холбоотой байж болох юм.

ХОЁР. БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ (Өвөрхангай аймаг, Хийморьтны ухаан ТББ)

Зорилго: Бага үнийн дүнтэй шүүхийн шийдвэрийг биелүүлэх явцад төлбөр авагчдад тулгардаг хүндрэл бэрхшээлийг тодорхойлох

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.7, Хууль зүйн сайдын 2013 оны А/181 дүгээр тушаалын 1-р хавсралтаар баталсан “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тодорхойлох журам”-ын 2.1, 2.2-т заасны дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг төлбөр авагчтай харилцан тохиролцож, эсхүл тухайн үед мөрдөгдөж байгаа эрх бүхий байгууллагаас тогтоосон үйлчилгээний хөлсний хэмжээгээр тогтоохоор заасан байна. Гэтэл Өвөрхангай аймгийн ШШГА-ны дарга зардал гаргуулах журам баталж, 2015 онд 35 200 төгрөг, 2016 онд 40 300 төгрөгийг эхний ээлжийн зардал гэж тогтоожээ. Энэ зардал нь бага үнийн дүнтэй төлбөр авагчид хүндээр тусдаг байна. Үүний зэрэгцээ шатахуун, шийдвэр гүйцэтгэгчийн томилот, хоол, буудлын зардлыг нэмж гаргахад хүрдэг.
- Мониторингд хамрагдсан нэгэн төлбөр авагч эмэгтэй тэтгэлэг авахаар хөөцөлдөх, шаардлага тавихаар сөрөг хандлага, таагүй харьцаа үүсдэг тул тэтгэлэг авахаа зогсооход хүрсэн байна. Тэрээр үүнийг тайлбарлахдаа шийдвэр гүйцэтгэгчээс тэтгэлгээ гаргуулахаар хөөцөлдөх үед “Тэжээж чадахгүй бол хүүхдээ яах гэж өсгөж байгаа юм бэ, чадах хүнд нь өгөх хэрэгтэй”, “хүүхдийн тэтгэлэг бол цалин хөлс биш учир сар бүр нэхээд явах шаардлагагүй” гэжээ.
- ШШГА-ны харуул хамгаалалтын ажилтнууд ёс зүйгүй ханддаг. Тухайлбал, хүүхдийн тэтгэлэг авагчдыг “Боовны мөнгөө авагчид” хэмээн доромж нэрлэдэг.

ГУРАВ. ШҮҮХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ АЖИЛЛАГАА (Өвөрхангай аймаг, Эх нутаг ТББ)

Зорилго: Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны дэг сахиулах үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөх



- Тахарын алба татан буугдахаас өмнө шүүх хурал бүрт дэг сахиулагч оролцдог байсан бол одоо зайлшгүй шаардлагатай хурлуудад дэг сахиулагч оролцож байна. Мониторингд хамрагдсан шүүгчийн яриа: “Нэг удаа шүүгчид зөвлөлдөх тасалгаанд ортол араас нь хариуцагч дагаж орж ирээд хэрүүл хийсэн. Тахар байхад ийм зүйл гарч байгаагүй.”
- Шүүх хурлын дэг сахиулахад шаардлагатай зарим асуудал шийдэгдээгүй байна. Тухайлбал, гэрч, хохирогчийг тусгаарлах өрөөгүй, яллагдагч, шүүгдэгчийг түр саатуулах байргүй, шүүх хуралд оролцогчдын согтуурсан эсэхийг тогтоох багажгүй г.м.
- Хөдөө сумдад томилолтоор ажиллах шүүгчдийн аюулгүй байдлыг Тахарын алба байнга хамгаалж ирсэн бол татан буугдсанаас хойш цагдаагийн алба хаагчийг дагуулж явахад хүндрэлтэй болсон байна.
- Шүүх хурал оройтсон үед шүүгчдийг гэрт нь хүртэл хамгаалах, гэрч, хохирогч, хариуцагч, зохигч нарыг албадан авч ирэх, шүүхэд дуудаад ирэхгүй байгаа хүмүүсийг эрэн сурвалжлах, хаяг тогтоох, цагдан хорих байранд шүүгдэгчийг хуяглан хүргэх тал дээр ухралт гарсан.
- Тахарын албаны зарим чиг үүрэг цагдаагийн байгууллагад шилжиж очсонтой холбогдуулан ажлын ачаалал, нийгмийн асуудал тэр дундаа ажил үүргээ явуулахтай нь холбогдуулан томилолт, унаа, багаж хэрэгслийн асуудлыг шийдэх шаардлагатай болохыг мониторингд хамрагдсан талууд гаргаж тавьсан. Тухайлбал, шөнөжин эргүүлд явсан цагдаагийн алба хаагчийг шүүх хуралд оруулдаг. Үүний зэрэгцээ цагдаагийн алба хаагчдад хуулиар хүлээлгэсэн үүрэгт ажил олон байна.

ДӨРӨВ. ОЛОН НИЙТИЙН ЦАГДААГИЙН АЖИЛТНЫ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ (Өмнөговь аймаг, НДЭХ-ний салбар ТББ)

Зорилго: Олон нийтийн цагдаагийн ажилтны үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтэд үнэлгээ хийх, илэрсэн зөрчил дутагдлыг засах зорилгоор нөлөөлөл явуулах, иргэд, иргэний нийгмийн хяналт оролцоог бий болгоход хувь нэмрээ оруулах

- Олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллах болсноор гэмт хэрэг, зөрчил буурахад бодитой үр дүн гарч байна гэж нутгийн өөрөө удирдах байгууллага, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага үзэж байна. 2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 44 зөрчлийн газрыг хамгаалан ажиллаж, архи дан согтуурсан дуудлагын дагуу 107 иргэнийг саатуулах байранд хүргэж өгч, 24 иргэнийг түргэн тусламжид хүлээлгэн өгч, гудамж талбайд жижгээр танхайрсан, архи дан согтуурсан 1 085 хүнд зөвлөгөө өгч, 83 иргэнд сэрэмжлүүлэг өгч, гэрэл, дохио зөрчсөн 290 тээврийн хэрэгслийн эзэмшигчид мэдэгдэх хуудас хүргэжээ.
- Хөдөлмөрийн гэрээнд илүү цагийн хөлс олгож болохоор заасан хэдий ч олон нийтийн цагдаагийн ажилтанд илүү цагаар ажилласан хөлсийг олгохгүй байна.



Олон нийтийн цагдаагийн ажилтнаар томилогдох үед 21 хоногийн сургалтад суудаг бөгөөд түүнээс цааш ямар нэг сургалт, дадлагажуулах хөтөлбөр байхгүй байгаа нь үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг хязгаарладаг.

- Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэмт хувцасны материал муу, хавар, өвлийн хувцас, гутал олгодоггүй. Зарим нэг нь гандаж муудахаар өөрсдийн мөнгөөр хувцас захиалж хийлгэдэг. Холбоо, хамгаалах тусгай хэрэгслээр хангах үүрэгтэй ч зөвхөн гав, хутганы бээлий л олгосон. Тиймээс цалингаасаа шүгэл, дохиур мод, гар чийдэн, цахилгаан бороохой худалдаж авсан байна.
- Олон нийтийн цагдаагийн ажилтны ажлыг дүгнэх 0-100 онооны үзүүлэлт гаргасан ч торгууль ногдуулсан, зөрчил таслан зогсоосон г.м үзүүлэлтийг үнэлэх боломжгүй байна. Тиймээс бичмэл тайланг үндэслэн ажлыг нь үнэлдэг.

ТАВ. БАГИЙН ЦАГДААГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИРГЭДИЙН ОНООНЫ КАРТААР ҮНЭЛГЭЭ ХИЙХ НЬ (Хөвсгөл аймаг, Хөвсгөл далай ээж ТББ)

Зорилго: Багийн цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааг иргэдийн оролцоотой үнэлэх шалгуур үзүүлэлт гаргаж, үнэлгээг хийх замаар иргэд цагдаагийн хамтын ажиллагааг бий болгоход дэмжлэг үзүүлэх

- Аль ч багийн иргэдээс өгч байгаа гомдол мэдээлэл аймгийн цагдаагийн газрын жижүүрт бүртгэгдэж, тэндээсээ нутаг дэвсгэр хариуцсан цагдаа руу хуваарилагдан очдог тул иргэд хариугаа хаанаас авахаа мэддэггүй.
- Багийн хэсгийн байцаагчид хариуцсан багаасаа алслагдсан байршилд буюу аймгийн Цагдаагийн газарт байрладаг тул иргэдтэй тулж ажиллах боломжийг хязгаарладаг. Үүний зэрэгцээ багийн хэсгийн байцаагчдын кабин шилэн ханаар тусгаарлагдсан, дуу чимээг тусгаарлагчгүй тул гомдол санал гаргаж буй иргэдийн яриа бүх хүнд тод сонсогддог. Мөн хэсгийн байцаагчдын нэр хаяг тус бүрдээ тавигдаагүйгээс иргэд өөрсдийн хариуцсан байцаагчтайгаа уулзахад хүндрэл учирдаг байна.
- Багтаа ажиллах төсөв зардал, тухайлбал, унаа, харилцаа холбооны зардал өгдөггүй тул өөрсдийн мөнгөөр өөрсдийн унаанд түлш хийж ажилладаг. Өөр хоорондоо үнэгүй ярих урамшуулал зарласан үед дугаар авдаг тул утасны дугаар байнга солигддог. Наад захын зардал байхгүйгээс иргэдээс гаргуулахад хүрдэг бөгөөд үүнээсээ болж шүүмжлэлд өртдөг.

МОНИТОРИНГИЙН ОЛОЛТ, АМЖИЛТ

Өвөрхангай аймаг

- Орон нутгийн шүүх, ТББ-ын хооронд харилцаа холбоо бий болсон.
- Мониторингийн дүнд тулгуурлан хүүхдийн тэтгэлэг авагчдад зориулсан гарын авлага бэлтгэж, түгээлээ. Мөн хүүхдийн тэтгэлэг авагчдад зориулан үйлчилгээ үзүүлдэг клуб байгуулагдав.
- Гурван хүүхдийн тэтгэлэг авагчийг сонгон, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласны дүнд 4 гүйцэтгэх хуудасны мөнгөн дүнгээр 5 600 000 төгрөгийн тэтгэлэг, тодорхой тооны мал, иж бүрэн гэр олгууллаа.

Хөвсгөл аймаг

- Хөвсгөл аймгийн ИТХ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл мониторингийн тайланг ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн, шийдвэр гаргуулахаар төлөвлөгөөндөө тусгасан.
- Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар, хэсгийн байцаагчид иргэдэд тавидаг тайлангийн чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх талаар Мониторингийн багтай санал солилцов. Мөн ирэх жилийн ажлаа мониторингид ашигласан шалгуур үзүүлэлтээр дүгнэхээр тохиролцов.
- Багийн нийтийн хуралд тус мониторингийн тайланг сонсохоор Мөрөн сумын ИТХ-тай тохиролцлоо.



- Баг хариуцсан цагдаагийн ажилтны ажлын ачаалал нормт хэмжээнээс 1,3-2,2 дахин их байдгаас үүдэлтэй иргэдэд хүрч ажиллах боломжийг хязгаарлаж байна.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр эрх зүйн орчин дутмагаас үүдэн дорвитой ажиллаж чадахгүй, иргэдийн итгэлийг алдаж байна.
- Багийн Засаг дарга хэсгийн байцаагчтай хамтарч ажиллах ажиллагаа сул. 9 багийн 6 баг хамтран ажиллах төлөвлөгөө баталсан ч дүгнээгүй, 2 багийн Засаг дарга цагдаагийн хэсгийн байцаагчтайгаа огт уулзаагүй байна. Харин 12-р багийн Засаг дарга, цагдаагийн хэсгийн байцаагч байнга хамтран ажилладаг бөгөөд үр дүн нь гэмт хэргийн гаралтыг буурахад нөлөөлсөн гэж дүгнэхээр байлаа.
- Багийн нутаг дэвсгэрт явуулж буй цагдаагийн байгууллагын ажлыг иргэдээс асуулга авч, үүний зэрэгцээ тусгай онооны картаар үнэлгээ авах аргад суралцсан иргэдээр үнэлүүлэхэд ялгаатай дүн гарч байна. Ерөнхийдөө цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг мэдэхгүй иргэд муу гэсэн үнэлгээг өгч байхад онооны картаар үнэлж байгаа иргэд мэдээлэлд тулгуурлан үнэлгээг хийхдээ ихэвчлэн 70 түүнээс дээш буюу сайн гэсэн үнэлгээг өгчээ. Эндээс дүгнэхэд цагдаагийн байгууллага иргэдэд ажлаа тайлагнаж, мэдээллээ ил тод байлгах нь цагдаа, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах, олон нийтэд түшиглэн ажиллах зорилтдоо хүрэхэд чухал алхам болохыг харуулж байна.

ЗӨВЛӨМЖ

Нэг. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТУХАЙД

- Өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн болохыг эргэж мэдэгддэг байх
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд иргэдийн сэтгэл ханамж дундуур байгааг судалж үзэж, үйл ажиллагаагаа сайжруулахдаа үр дүнг ашиглах
- Цагдаагийн байгууллага жилийн ажлаа тайлагнахдаа тухайн жилд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаархи дүн мэдээг баг тус бүрээр гаргаж, оршин суугчдад тайлагнадаг байх

Хоёр. БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН ТУХАЙД

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, алба хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх ажил зохион байгуулах, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдад хариуцлага тооцох
- Бага үнийн дүнтэй шийдвэр тус бүрд эхний ээлжийн зардлын дүн тогтоосон шийдвэрээ хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөх
- Шийдвэр гүйцэтгэх хуудсыг ном журмын дагуу хөтлөх
- Бага үнийн дүнтэй, ялангуяа хүүхдийн тэтгэлэг авагчдын шүүхийн шийдвэрийн биелэлтийг сайжруулах ажлыг бодлогоор дэмжих, тухайлбал, шийдвэр гүйцэтгэгчийн ажлын үзүүлэлтэд оруулах г.м



Гурав. ШҮҮХ, ШҮҮГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙД

- Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах Тахарын албаны чиг үүрэг бусад хууль сахиулах байгууллагад шилжсэнтэй холбогдон үүсч буй хүндрэлийг цогцоор шийдвэрлэх, үүнд:
 - шүүх хуралдааны дэг сахиулагчийг өмнөхийн адил хуралдаан бүрт оролцуулах,
 - шүүх хурал оройтож тарах, шүүх нүүдэллэн ажиллах үеэр шүүгчийн аюулгүй байдлыг хамгаалах, энэ ажлыг хариуцан ажиллах цагдаагийн алба хаагчийн томилолт, унааны зардлыг шийдэх,
 - шүүх хуралдааны дэг сахиулахад шаардлагатай гэрч, хохирогчийг тусгаарлах, шүүгдэгч, яллагдагчийг түр саатуулах байртай болгох, согтуурсан эсэхийг тогтоох багажаар хангах г.м

Дөрөв. ОЛОН НИЙТИЙН ЦАГДААГИЙН ТУХАЙД

- Олон нийтийн цагдааг чадавхжуулах сургалт, дадлагын хөтөлбөрийг баталж, тодорхой давтамжтай хэрэгжүүлэх
- Олон нийтийн цагдааг батлагдсан орон тоогоор ажиллуулах
- Олон нийтийн цагдаагийн илүү цагийн хөлсийг гэрээнд заасны дагуу олгох
- Олон нийтийн цагдаагийн дүрэмт хувцасны материалд стандарт тогтоох, 4 улиралд тохирох хөдөлмөрийн хувцсаар хангах
- Олон нийтийн цагдаад олгохоор хуульд заасан нэг бүрийн болон хамгаалах тусгай хэрэгслээр хангах

Тав. БАГИЙН ЦАГДААГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙД

- Багийн хэсгийн байцаагч нутаг дэвсгэр дээрээ ажлаа явуулах ажлын байр /кубон/-ыг бий болгох
- Багийн Засаг дарга, хэсгийн байцаагчтайгаа хамтран ажиллах төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг улирал, хагас жил, бүтэн жилээр дүгнэж хэвших
- Багийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй айл өрх, иргэдийн судалгааг Багийн засаг дарга, багийн цагдаагийн хэсгийн байцаагчтай хамтран хийх
- Багийн хэсгийн байцаагчийн ажлын ачааллыг нормд нийцүүлэн тогтоох
- Хэсгийн байцаагчийн унаа, харилцаа холбооны зардлыг шийдэх



НЭЭЛТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамьян гүний гудамж -5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 14240,
Утас: (976-11) 313207
Факс: (976-11) 324857

Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилт, арга зүйн дэмжлэгтэйгээр төрийн үйлчилгээний ил тод, хариуцлагатай байдал амьдралд хэр бодитой хэрэгжиж байгаад төрийн бус байгууллага (ТББ)-ууд мониторинг хийдэг билээ. Мониторингийн гол үр дүнг энэхүү МОНИТОР цувралаар олон нийтэд хүргэхийн сацуу төрийн үйлчилгээг цаашид боловсронгуй болгох чиглэлээр мониторинг хийсэн байгууллагууд нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг юм.